

Хэлний бодлогын талаар дэвшүүлсэн Венийн санал - Нийгмийн оролцоог сайжруулахад тавих 11+1 шаардлагууд

Хэлний бодлогын талаар дэвшүүлсэн Венийн саналыг Вена хотод зохион байгуулагдсан Олон улсын герман хэлний багш нарын XVII их хурлын ([IDT 2022](#)) өмнө олон улсын мэргэжилтэн багш нарын баг боловсруулан гаргасан бөгөөд уг саналыг тус их хурлын үеэр танилцуулж, 2022 оны 08 сарын 20-ны өдрийн хаалтын арга хэмжээн дээр баталсан юм. “Өнөөгийн нийгэм дэх хэлний оролцоо” хэмээх хурлын уриаг баримтлан эдгээр саналыг улс төрийн түвшний болоод мэргэжлийн хүмүүст хандан боловсруулсан юм.

Хэл сурахуй ба сургахуйн, тэрчлэн мэргэжлийн түвшинд хязгаарлагдмал хэлний боловсролын хамгийн чухал зорилго нь дискурсийн чадамжийг хөгжүүлэхэд оршино. Дискурсийн чадамж гэдэг нь шийдвэр гаргах үйл явцад хариуцлагаа ухамсарлан нөлөөлж оролцох болоод нийгмийн адил тэгш эрхтэй оролцоог хангах, дэмжих явдал юм.

1. Герман хэл сурах үйл нь **олон хэл зэрэгцэн оршиж буй нийгэмд** өрнөж байна. Суралцагч нар нь өөрсдөө олон хэлтэй, олон өөр соёлын туршлага, чадамжтай хичээлд оролцож байгааг анхааран авч үзэх шаардлагатай. Үүнийг нийгэм, хувь хүний нөөц чадавх, тэрчлэн дэлхийн болон бүс нутгийн өгөгдөл, хэтийн төлөвийг харгалзан авч үздэг хэлний бодлогоор дэмжих нь зүйтэй. Нийгэм дэх олон хэл, соёлын ялгаатай байдлыг сургалтын материал болон сургалтын хөтөлбөр боловсруулах, сургалт зохион байгуулах, хичээлийн агуулгыг сонгох, мэргэжлийн боловсрол олгох, мэргэжил дээшлүүлэх сургалт зохион байгуулах, судалгаа хийх зэрэгт тусгах шаардлагатай байна.
2. **Олон улсын хамтын ажиллагааг** санхүүгийн болон бүтцийн хувьд хялбаршуулж дэмжих нь зүйтэй. Бүх тал эрх тэгш байж, хамтын ажиллагааг нээлттэй, ил тод солилцоон дээр тулгуурлан явуулбал хамтын ажиллагаа илүү амжилттай хэрэгжих юм. Хамтын ажиллагааны нээлттэй, ил тод солилцоо явуулахад холбогдох нөхцөл байдлын баталгааг хангах нь зүйтэй. Онцгой дэмжлэг туслалцаа авч хүлээн зөвшөөрөгдөхөд Герман хэлийг гадаад хэл болон хоёрдогч хэл болгон заах багш нарын мэргэжлийн холбоод харилцаа холбооны сүлжээ болон мэргэжилтний дүгнэлтийг дамжуулах, түгээх үүрэг даалгаврыг өөрийн байр сууриар дамжуулан хэрэгжүүлэх шаардлагатай.
3. Герман хэл сурахуй, сургахуйн үндсэн зарчим нь **өөрийн чадавх, бие даасан байдлыг бэхжүүлэх** санаа юм. Хүний хэлний чадамж нь анхнаасаа өөрийн удирдлагатай суралцахуй болон нийгэм, ажлын байран дахь оролцоогоор дамжин тогтсон байдаг. Суралцагчдын ялгаатай ашиг сонирхол, хэрэгцээ шаардлагыг тэдний хэрэгцээнд тулгуурласан, олон талт сургалтыг санал болгосноор хангах нь зүйтэй. Суралцагчид бол “хүний нөөц” биш, харин тэднийг өөрсдийн нэр төр бүхий хувь хүн гэж үзэж хамгаалах хэрэгтэй. Үүнийг мэргэжлийн чиг баримжаа олгох герман хэлний хичээл, насанд хүрэгчдийн боловсрол, хэл сурахуй ба сургахуйн үйлийн аль алинд авч үзэх хэрэгтэй.
4. Нийгмийн үйл явцад оролцох оролцоог хэл ярианы урын сангаар бүрдүүлэх боломжтой. Тиймээс шилжин суурьших нөхцөл байдалд хэлний боловсролыг **шилжин ирэгсдийн амьдралын бодит байдал**, тэдний ажил мэргэжил, амьдралтай нь уялдуулж олгох нь зүйтэй. Тэдний хэлний мэдлэгийг оршин суух тухай асуудлаас нь ангид авч үзэх хэрэгтэй бөгөөд хөдөлмөрийн зах зээл буюу нийгмийн халамж, үйлчилгээтэй холбогдуулан тавих гол үндсэн нөхцөл болгон шаардах учиргүй юм. Хэл яриаг ялгаварлан гадуурхах хэрэгсэл болгон ашиглах учиргүй.
5. Ерөнхий боловсролын сургуулийн орчин дахь герман хэлний сургалтын хөтөлбөрийн гол зорилго нь сурагчдын сурах хүсэл, нөөц чадварыг эх сурвалж болгон ашиглах замаар тэдэнд хэлний боловсрол олгох мөн нийгмийн хүрээний

зөөлөн ур чадваруудыг төлөвшүүлэхэд оршино. Иймд сургуулийн өмнөх боловсролоос эхлүүлэн бүрэн дунд боловсролыг эзэмшиж дуусах хүртэлх нийт хугацааны сургалтын цөм хөтөлбөр болон зорилтуудыг дээрх гол зорилгод уялдуулан боловсруулж, сурагчдад хэлний боловсрол олгох, хэлний дэмжлэг үзүүлэх сургалтын үйл ажиллагаануудыг тууштай тасралтгүй хэрэгжүүлэх шаардлагатай.

6. Дээд боловсролын салбарт судалгаа, шинжилгээний ажил эрхэлж буй оюутан, багш, судлаачдын амжилтыг сайжруулахад чухал нөлөө бүхий судалгааны хөдөлгөөнт байдал, хамтын ажиллагааны боломжуудыг сайжруулахын тулд төр засгаас олгож буй сургалтын тэтгэлэг, судалгааны санхүүжилтийг нэмэгдүүлэн, судлаачдад дэмжлэг үзүүлэх нь зүйтэй. Хэл шинжлэлийн салбарт хүчин зүтгэж буй багш, оюутан, судлаачдад тэдгээрийн нийгмийн гарал үүсэл, эдийн засгийн байдлаас үл хамааран судалгаа шинжилгээний ажлаа саадгүй зохион явуулах, нэн ялангуяа герман хэлтэй улс орнуудад суралцах, судлах боломж гарцыг олгож, дэмжиж ажиллах шаардлагатай.
7. Герман хэл судлалын бүх чиглэлээр хийгдэж буй эрдэм шинжилгээ, судалгааг улс төрийн бодлогоос хараат бус байлгаж, түүний эрх чөлөө болон олон ургальч үзлийг дээдлэх шаардлагатай. Эдгээр судалгааны үр дүнг төрийн бодлогын түвшинд хүлээн зөвшөөрч, шаардлагатай тохиолдолд боловсролын бодлого, чиглэлд тусгах хэрэгтэй. Мөн түүнчлэн олон шинжлэх ухааны уулзвар дээр болон олон улсын хамтын ажиллагааны хүрээнд хийгдэж буй судалгааг мэргэжлийн салбар болон дэлхий нийтэд зориулсан шинжлэх ухааны хөгжилд оруулж буй хувь нэмэр хэмээн үзэн хөхүүлэн дэмжих хэрэгтэй юм.
8. Бүх багш нарыг мэргэжил дээшлүүлэх чанартай сургалтанд хамрагдах боломжоор хангахын зэрэгцээ мэргэжлийн салбарын шинэ дэвшил хөгжлийг нутагшуулахдаа тухайн бүс нутаг, уламжлалт сургалтын онцлогийг харгалзан үзэх нь зүйтэй. Сурган хүмүүжүүлэгч нарын санхүүгийн ялгавартай чадамж нь мэдлэг чадвараа дээшлүүлэхэд саад болох ёсгүй бөгөөд тэднийг ажлын байран дээр мэргэжил дээшлүүлэх боломжоор бүх талаар ханган, тусалж дэмжих хэрэгтэй юм.
9. Албан болон албан бус боловсролын байгууллагуудад ажиллаж буй багш нарын хөдөлмөрийн нөхцөлийг сайжруулах ёстой. Үүнд: Хичээлийн цаг болон хичээлийн бэлтгэл, сайжруулалтын хоорондох тэнцвэрт харьцаа, тохирсон цалин хангамж багтана. Мөн хөдөлмөрийн гэрээг урт хугацаанд байгуулж, багшийг мэргэжил дээшлүүлэх боломжоор хангах нь зүйтэй.
10. Дижитал шилжилт нь хэл сурах болон сургах үйлд олон талт, олон шинэ боломжийг бидэнд нээж өгсөн. Жишээлбэл энд зайн сургалт, бие даан суралцах үйл явц, виртуал анги зэргийг нэрлэж болно. Энэхүү дижиталчлал нь хэл судлал, хэлний бодлогын хүрээнд дэх олон улсын хамтын ажиллагааг хялбар болгож байна. Дижитал хэлбэрээр зохион байгуулагдаж буй бүхий л үйл ажиллагаа, арга хэмжээ нь танхимын уулзалт, хурал цуглааныг үнэндээ орлож чадахгүй. Энэхүү өөрчлөлт нь мөн шууд уулзаж болох бидний хувийн нөөц бололцоог үгүй хийж болохгүй. Дижиталчлал нь оршин тогтнож буй цаг хугацааны зэрэгцлэлийг хараахан бэхжүүлж чадахгүй байгаа ч дижитал ертөнцөд нэвтрэх боломжийг баталгаажуулах ёстой. Жишээлбэл энд техник, тоног төхөөрөмж, мэргэжил дээшлүүлэх сургалт, семинар зэргийг нэрлэж болно.
11. Герман хэл сурах үйлийг “гоо зүй, соёлын тусгал бүхий суралцахуйг багтаасан, орчиндоо ээлтэй амьдралын хэв маяг, хүний эрх, хүйсийн тэнцвэрт байдлын нэгдмэл харилцааг бий болгох хэлний боловсрол” гэж үзэж болно. Хэл сурах үйл нь хэл сурах, харилцааны, соёлын ялгаатай байдалд дасан зохицох чадвараар дамжуулан хүчирхийлэлгүй, энх тайвны соёл болон соёлын олон талт байдлыг үнэлэх

үнэлэмжийг дэмжих ёстой. Ингэснээр хэл сурах үйл нь тогтвортой хөгжил, олон улсын түвшний хандлагыг сайжруулахад үнэтэй хувь нэмэр оруулна.

Өнөөг хүртэл хэлний бодлогыг хөндлөнгийн зүйл мэт харсаар иржээ. Тиймээс үүнийг бусад бодлогын талбаруудтай ижил түвшинд тэгш байдлаар байршуулан, бие даасан бодлогын талбар болгож авч үзэх ёстой. Хэлний бодлогыг бие даасан бодлогын талбар болгон авч үзэх нь улс орон бүрийн төрийн болон төрийн бус байгууллага, холбоодын үүрэг даалгавар юм. Энэ нь мөн нийгмийн болон бие даасан олон хэлт байдал, оролцооны зорилгын үндэс суурь гэж ойлгогддог.

2022 оны 8 сарын 20

Санал болгох ишлэл: Хэлний бодлогын талаар дэвшүүлсэн саналын ажлын хэсэг 2022: Олон улсын герман хэлний багш нарын холбооны 2022 оны 17-р чуулга уулзалтын үеэр “Хэлний бодлогын талаар дэвшүүлсэн Венийн санал”-ын хүрээнд баталсан.

Онлайн: <https://www.idt-2022.at/site/dieidt/sprachenpolitischethesen>

Ажлын хэсгийн гишүүд: Rudolf de Cillia, Anna-Katharina Draxl, Renate Faistauer, Thomas Fritz, Matthias von Gehlen, Monika Janicka, Matthias Jung, Puneet Kaur, Liana Konstantinidou, Inger Petersen, Sandra Reitbrecht, Julia Ruck, Hannes Schweiger, Brigitte Sorger, Thomas Studer